



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/248


Сүхбаатар сум

Бага боловсролын шинэ анги нээх
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.6 "г", Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 30 дугаар зүйлийн 30.1.3, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын "Спорт"-ын сургуульд бага боловсролын 1-5 дугаар ангийг шинээр нээн ажиллуулах эцэг, эх, асран хамгаалагчид, сургуулийн захиргааны хүсэлтийг харгалзан үзэж, тус сургуульд бага боловсролын 1-5 дугаар ангийг шинээр нээн ажиллуулах эрхийг олгож, сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. "Бага ангийн сургалтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг чанартай зохион байгуулж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үйл ажиллагаанд амжилт гаргаж, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр"-ийн 3.2.1.5, 3.2.2.2, 3.2.4.3, 3.2.5.1, 3.2.5.4 дэх заалтуудын хэрэгжилтийг ханган авилга, ашиг сонирхол, ёс зүй, санхүүгийн зөрчил дутагдалгүй ажиллахыг Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын "Спорт"-ын сургуулийн захирал /О.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

430810586